



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A/18

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө худалдаж авах тухай ┐

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.7 дах заалт болон Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт албан хаагчдын хэрэгцээнд “Ус цэвэршүүлэгч-халаагч” худалдаж авах ажил зохион байгуулахыг Ус хангамж ариутгах татуургын инженер Ч.Батхишиг-т үүрэг болгосугай.
2. “Ус цэвэршүүлэгч-халаагч” худалдаж авах үнэ болох 1,088,000 /Нэг сая наян найман мянган / төгрөгийг багаж, техник хэрэгсэл зардлаас санхүүжүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг нягтлан бодогч Г.Батням-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хянал тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга Г.Цэнджав-т даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600018